



Ирээд, Намайг дага ҮЙЛ АЖИЛЛАГАА

Гэр бүлийн үдэш, судраас судлах зэрэг зугаатай үйл ажиллагаанд зориулав!

7-р сарын 1-7


Аз жаргалын төлөвлөгөөг дүрсэлсэн гар урлал

АЛМА 17-22

Аарон, Аммон хоёр Тэнгэрлэг Эцэгийн аз жаргалын төлөвлөгөөний талаар заасан. Тэд үүнийг гэтэлгэлийн төлөвлөгөө (Алма 18:36-39 мөн Алма 22-ыг үзнэ үү) гэж нэрлэсэн. 12-р хуудас дээр очиж, аз жаргалын төлөвлөгөөг дүрсэлсэн гар урлал хий.

Бага насны хүүхдүүдэд зориулав:

Хүүхдийнхээ нялх үеийн зургийг хайж ол. Нялх байх үеэсээ хойш хэр зэрэг өсөж том болсныг нь онцолж хэл! Дараа нь Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөөний нэг хэсэг болох дэлхий дээр хэрхэн өсөж хөгжих талаар ярилц.



7-р сарын 8-14

Бурханы мутар дахь зэмсгүүд

АЛМА 23-29

Аммон ах нартаа “Бид энэ агуу ажлыг гүйцэлдүүлэхэд Бурханы мутар дахь зэмсгүүд болгогдсон” (Алма 26:3) хэмээн айлджээ. Ая зохиоход ашиглах эд зүйлсийг цуглуул. Дараа нь хөгжмийн цохилт болон ая зохиогоорой. Бид ая зохиохдоо зэмсгүүд ашигладагтай адил Бурхан Есүс Христийн Сүмийг байгуулахад туслуулахаар биднийг ашиглаж болно.

Бага насны хүүхдүүдэд зориулав:

Энгийн саадтай зам хий. Үүгээр явах дадлага хий! Дараа нь саадудыг авч, дахин оролд. Аммоныг ах нартайгаа хамт леменчүүдийн газар нутагт сайн мэдээг заахыг хүсэх үед леменчүүдийн хаан хэрхэн саад бэрхшээлийг байхгүй болгосон талаар тайлбарла (Алма 23:3).

7-р сарын 15-21

Хөгжимт сандалтай сануулга

АЛМА 30-31

“Бүх зүйл Бурхан байдгийг үзүүлдэг” (Алма 30:44) хэмээн Алма заасан. Энэ нь Бурхан Өөрийнх нь тухай бидэнд сануулах бүх зүйлийг бүтээсэн гэсэн үг юм. Хүн бүрд зориулан сандал тойруулан засахдаа нэг сандал дутуу тавь. Хэн нэгэн ая тоглуулах ба ая хэзээ зогсохыг тоглуулж буй хүн шийднэ. Ая зогсох үед бүх хүн сандал дээр сууна. Сандалгүй үлдсэн хүн Бурханыг сануулдаг нэг зүйлийг хуваалцана. Бүх хүний хуваалцах ээлж иртэл үргэлжлүүл.

Бага насны хүүхдүүдэд зориулав:

Гадаа эсвэл гэрээ тойрон алх. Чамайг аз жаргалтай болгодог мөн Тэнгэрлэг Эцэгийн талаар чамд сануулдаг зүйлсийг хайж ол.



7-р сарын 22-28

Гэрчлэлээ өсгөх нь

АЛМА 32-35

Алма Бурханы үгийг сонсож, итгэлээ харуулах зүйлсийг хийх үед гэрчлэл чинь мод адил өсөх болно гэж заасан (Алма 32:37-г үзнэ үү). Ус, нарны гэрэл зэрэг мод ургахад туслах зүйлсийг зур. Дараа нь сүмд явах, залбирах зэрэг гэрчлэлээ өсгөхөд туслах зүйлсийг зураарай.

Бага насны хүүхдүүдэд зориулав:

“Итгэл” (Хүүхдийн дууны ном, 50-51) дууг дуул. Дуулж байхдаа үрийг өндөр ургаж, том болж байгааг харуулах үйл хөдлөл хийгээрэй. Гэрчлэлээ өсгөх тухай ярилц.



ЗУРАГ ЧИМЭГЛЭЛИЙГ ХЭЙТИ ДОКРИЛЛ